



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 09 сарын 29 өдөр

Дугаар 1/230

Мандалговь

Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж буй
иргэдэд бүтээн байгуулалтын ажилд
оролцуулах тухай

Монгол Улсын “Цэргийн албаны тухай хууль”-ийн 30 дугаар зүйлийн 30; 30.2; 30.3 дугаар зүйл, Засгийн газрын 2018 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Цэргийн албыг дүйцүүлэн хаах журам”-ын 3.2.7, Цэргийн дүйцүүлэх албаны мөнгийг зарцуулах журмын 4.1.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Орон нутагт нэг түмэн мод тарих арга хэмжээний хүрээнд Сайнцагаан сумын цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж буй иргэдийг зарлан дуудаж бүтээн байгуулалтын ажилд оролцуулсугай. .

2. Уг бүтээн байгуулалтын ажилд хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангуулж, Коронавирус /Covid-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Цэргийн штабын дарга (дэд хурандаа Ш.Гансүх)-д үүрэг болгосугай.

3. Цэргийн албыг дүйцүүлэн хааж байгаа иргэдийн хоолны зардалд шаардагдах 197,100 (Нэг зуун ерэн долоон мянга нэг зуун) төгрөгийг Цэргийн дүйцүүлэх албаны хөрөнгөөс гарган зарцуулахыг нягтлан бодогч (М.Янжиндолгор)-д нарт зөвшөөрсүгэй.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

Л.БАЯРСАЙХАН



48021124